

Бүгд Найрамдах Ардчилсан Герман
Улс, Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын хооронд иргэний болон гэр
бул, эруугийн хэргийн талаар
эрхийн туслалцаа узуулэх тухай
ГЭРЭЭ

Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс тус хоёр орны ард түмний ах дуугийн найрамдал, хамтын ажиллагааг цаашид эрхийн харилцааны салбарт бэхжүүлэн хөгжүүлэх эрмэлзлэлийг удирдлага болгон, социализма байгуулалтыг хангах, хоёр орны иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгын ууднээс иргэний болон гэр бул, эруугийн хэргийн талаар эрхийн туслалцаа узуулэх тухай Гэрээ байгуулахаар шийдвэрлэж,

энэ зорилгоор өөрийн бүрэн эрхт төлөөлөгчдөөр:

Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын Төрийн Зөвлөлийн даргаас Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Шуух яамны сайд доктор Курт ВЮНШЕ,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Цэвэгжавын ПУНЦАГНОРОВ нарыг тус тус томилоноор тэдгэх хэлбэр журмын дагуу үйлдэгдсэн бүрэн эрхийнхээ үнэмлэхийг харилцан солилцоод дор дурдсан зүйлийн талаар хэлэлцэн тохиролцов:

Нэгдүгээр бүлэг

Эрхийн хамгаалалт

Нэгдүгээр зүйл

Эрхийн хамгаалалтын хэмжээ

I. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат Хэлэлцэ. Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байхдаа хувийн болон эд хөрөнгийн эрхээ нөгөө Этгээдийн харьяатын нэг